

Боловсруулалт хийгдэж байгаа

ИНД - 175

Иргэний нисэхийн ерөнхий газар

**Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллага –
Гэрчилгээжүүлэлт**

ДҮРМИЙН ТАЙЛБАР

Энэхүү дүрэм нь дараах зүйлсийг агуулна –

- Иргэний нисэхийн ерөнхий газрын нэрийн өмнөөс Монгол Улсад нисэхийн мэдээллийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагын гэрчилгээжүүлэлт болон үйл ажиллагаатай холбоотой дүрмүүд;
- Монгол Улсын Нисэхийн мэдээллийн эмхтгэл, Нисэхийн мэдээллийн цуврал болон NOTAM мэдээнд тавигдах шаардлагууд.

Энэхүү дүрэм нь ИНЕГ-ын эрхлэн гаргасан ИНД-175 дүрмийн одоо мөрдөгдөж буй бүрэн хувилбар бөгөөд зөвхөн лавлагааны зориулалттай. Зам, Тээврийн сайдын баталсан дүрмээс хөрвүүлсэн болно. Зам, Тээврийн сайдын баталсан дүрэм, дүрмийн өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас авах эсвэл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

ДҮРМИЙН МЭДЭЭЛЭЛ

Энэ дүрэм нь 1994 оны 9-р сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд одоогийн байдлаар дараах өөрчлөлтүүдийг агуулсан болно:

Дүрмүүдийн жагсаалт

Абүлэг –Ерөнхий.....	7
175.1 Зорилго	7
175.3 Гэрчилгээний шаардлага	7
175.5 Гэрчилгээ авах өргөдөл гаргах	7
175.7 Гэрчилгээ олгох	7
175.9 Гэрчилгээгээр олгогдох эрхүүд.....	8
175.11 Гэрчилгээний хугацаа.....	8
175.13 Гэрчилгээний хугацаа сунгах	8
В бүлэг — Гэрчилгээжүүлэлтэд тавигдах шаардлагууд Error! Bookmark not defined.	
175.51 Боловсон хүчинд тавигдах шаардлагууд.....	8
175.53 Ажиллах орчинд тавигдах шаардлагууд	10
175.55 Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээний хамрах хүрээ	10
175.57 Баримтжуулалт	10
175.59 Мэдээлэл болон өгөгдөл цуглуулах	11
175.61 Нисэхийн мэдээллийг хэвлэх.....	12
175.63 Хэвлэгдсэн мэдээллийн алдааг залруулах.....	14
175.65 Бүртгэлүүд.....	15
175.67 Аюулгүй ажиллагааны удирдлага.....	15
175.69 Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааны заавар.....	15
С бүлэг — Үйл ажиллагаанд тавигдах шаардлагууд Error! Bookmark not defined.	
175.101 Байнгын нийцэл	17
175.103 НМЭ-ийн үйлчилгээ	17
175.105 NOTAM мэдээний үйлчилгээ.....	18
175.107 Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ.....	19
175.109 Гэрчилгээ эзэмшигч байгууллагад гарсан өөрчлөлт	20
175.111 Хүчингүй болгосон	
D бүлэг — Монгол Улсын Нисэхийн мэдээллийн эмхтгэл Error! Bookmark not defined.	
175.151 Монгол Улсын НМЭ-ийн агуулга.....	21
175.153 Монгол Улсын НМЭ-д тавигдах шаардлагууд	22
175.155 НМЭ-ийн Өөрчлөлтүүдэд тавигдах шаардлагууд	23
175.157 НМЭ-ийн Нэмэлтүүдэд тавигдах шаардлагууд	23

Е бүлэг — Нисэхийн мэдээллийн цувралууд.....	Error! Bookmark not defined.
175.201 Нисэхийн мэдээллийн цувралд тавигдах шаардлагууд.....	23
Ғ бүлэг — NOTAM мэдээ	Error! Bookmark not defined.
175.251 NOTAM мэдээнд тавигдах шаардлагууд.....	24
175.253 NOTAM мэдээг түгээх.....	25
Г бүлэг – Шилжилтийн үеийн заалтууд	Error! Bookmark not defined.
175.301 Нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч болон өргөдөл гаргагчдын шилжилтийн үе	25
175.303 Нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч болон өргөдөл гаргагчдын шилжилтийн үеийн дотоод чанар хангалт	27

А бүлэг – Ерөнхий

175.1 Үйлчлэх хүрээ

Энэхүү дүрэм нь дараах зүйлсийг агуулна –

- (1) Монгол Улсад нисэхийн мэдээллийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагын гэрчилгээжүүлэлт болон үйл ажиллагаатай холбоотой;болон
- (2) Монгол Улсын Нисэхийн мэдээллийн эмхтгэл, Нисэхийн мэдээллийн цуврал болон NOTAM мэдээнд тавигдах шаардлагууд.

175.3 Гэрчилгээний шаардлага

Энэ дүрмийн дагуу нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээгээр олгогдсон эрхийн хүрээнд, түүнд заасан шаардлагуудыг хангасан гэрчилгээ эзэмшигчээс өөр этгээд –

(1) Монгол Нисэхийн мэдээллийн районд;

(2) Шаардлагагүй

нисэхийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэхгүй.

175.5 Гэрчилгээ авах өргөдөл гаргах

Нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ хүссэн өргөдөл гаргагч нь ИНЕГ 175/01 маягтыг бөглөж дараах зүйлсийн хамт Даргад ирүүлнэ -

- (1) 175.69-д заасан үйл ажиллагааны заавар; болон
- (2) Хуулийн дагуу боловсруулсан дүрэм, журмуудад заасан зохих өргөдлийн хураамжийн төлбөр.

175.7 Гэрчилгээ олгох

Даргадараах шаардлагууд хангагдсан гэж үзсэн нөхцөлд өргөдөл гаргагчид нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ олгоно -

- (1) өргөдөл гаргагч В бүлгийн шаардлагуудыг хангасан; болон
- (2) 175.51(а)(1)-д заасан өргөдөл гаргагч ба өргөдөл гаргагчийн удирдах ажилтан эсхүл ажилтнууд нь **are fit and proper persons**; болон
- (3) гэрчилгээ олгосноор нисэхийн аюулгүй ажиллагааны **ашиг сонирхолд сөргөөр** нөлөөлөхгүй.

175.9 Гэрчилгээгээр олгогдох эрхүүд

Нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээнд гэрчилгээ эзэмшигчийн үзүүлэх эрхтэй нисэхийн мэдээллийн үйлчилгээнүүдийг заасан байна.

175.11 Гэрчилгээний хугацаа

(a) Нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээг 5 жил хүртэл хугацаагаар олгохөсхүлсунгаж болно.

(b) Нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ нь түүний хүчинтэй хугацаа дууссан эсхүл түдгэлзүүлсэн эсхүл хүчингүй болгох хүртэл хүчин төгөлдөр хэвээр байна.

(c) Нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч нь хүчинтэй хугацаа дууссан эсхүл хүчингүй болсон гэрчилгээг Даргад нэн даруйирүүлнэ.

(d) Түдгэлзүүлсэн нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээг сэргээх асуудлаар Даргад нэн даруй хандана.

175.13 Гэрчилгээний хугацаа сунгах

(a) Нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээний хугацаа сунгах өргөдлийгИНЕГ175/01маягтын дагуу гаргана.

(b)Өргөдлийг гэрчилгээндзаасан хугацаа сунгах өдрөөс өмнө эсхүл энэхүү өдрийг зааж өгөөгүй бол гэрчилгээний хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө Даргад ирүүлнэ.

В бүлэг — Гэрчилгээжүүлэлтэд тавигдах шаардлагууд

175.51 Боловсон хүчинд тавигдах шаардлагууд

(a) Нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ хүссэн өргөдөл гаргагч нь дараах ажилтнуудыг үндсэн ажилтнаар, гэрээгээр эсхүл өөр нөхцөлөөр ажиллуулна:

(1) Өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны зааварт тусгагдсан нисэхийн мэдээллийн үйлчилгээ бүрнэ дараах шаардлагууд хангагдсан болохыг бататгах эрх бүхий даргын албан тушаалтай удирдах ажилтан -

(i) үйл ажиллагааны шаардлагуудын дагуу үйлчилгээ үзүүлэх болон санхүүжих боломжтой; болон

(ii) энэ Дүрэмд заасан шаардлагуудын дагуу үйлчилгээ үзүүлэх; болон

(2) даргын албан тушаалтай удирдах ажилтны өмнөдараах үүрэг хүлээх удирдах ажилтан эсхүл ажилтнууд -

(i) байгууллага нь үйл ажиллагааны заавартаа нийцсэн үйл ажиллагаа явуулж байгааг бататгах; болон

(ii) дүрэм 175.67-ийн дагуу шаардсан аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо; болон

(3) өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны зааварт тусгагдсан нисэхийн мэдээллийн үйлчилгээнүүдийг үзүүлэхийн тулд нисэхийн мэдээллийг цуглуулах, эмхлэн цэгцлэх, шалгах, зохицуулах, боловсруулах болон хэвлэх хангалттай тооны боловсон хүчин.

(аа) Зүйл(а)(2)(ii)-т заасан удирдах ажилтан нь аюулгүй ажиллагааны удирдлага болон гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаануудтай холбогдох ур чадвар болон туршлагатай гэдгээ нотлон харуулах боломжтой байна.

(b) Өргөдөл гаргагч нь—

(1) үйл ажиллагааны зааварт тусгагдсан нисэхийн мэдээллийн үйлчилгээнүүдийг үзүүлэхийн тулд нисэхийн мэдээллийг шалгах, боловсруулах болон хэвлэх эрх олгосон ажилтнуудын ур чадварыг үнэлэх, сургах болон хадгалах журмыг тогтооно;

(2) шаардлагагүй

(3) эдгээр ажилтнуудад тэдэндолгогдсон эрхийн хамрах хүрээг заасан баримтыг бичгээр хангана.

175.53 Ажиллах орчинд тавигдах шаардлагууд

Нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ хүссэн өргөдөл гаргагч нь дараах шаардлагуудыг хангасан **оффис ажлын байр** болон ажиллах орчныг бүрдүүлнэ -

- (1) үйл ажиллагааны зааварт тусгагдсан нисэхийн мэдээллийн үйлчилгээнүүдийг үзүүлэхэд тохиромжтой;
- (2) 175.103(b) ба 175.105-ын холбогдох шаардлагуудыг хангасан.

175.55 Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээний хамрах хүрээ

Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээний чиглэлээр нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ хүссэн өргөдөл гаргагч нь нислэгийн өмнөх үйлчилгээнүүдтэй холбоотой дараах зүйлсийг үйл ажиллагааны заавартаа тусгасан байна -

- (1) хамрах газарзүйн бүс; болон
- (2) аэродромууд ба тэдгээрээс эхлэх агаарын замууд.

175.57 Баримтжуулалт

(a) Нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ хүссэн өргөдөл гаргагч нь -

- (1) гэрчилгээгээр олгогдсон эрхийн дагуу **хэвлэгддэг** нисэхийн мэдээллийн **формат болон стандартыг** баримтжуулна; болон
- (2) энэхүү формат болон **стандартыг** тогтоохдоо мэдээллийг ашиглах нөхцөл, хэрэглээг харгалзан үзнэ; болон
- (3) үйл ажиллагааны зааварт тусгагдсан нисэхийн мэдээллийн үйлчилгээнүүдэд шаардлагатай лавлагааны материал, **стандарт**, зөвлөмж, журмууд болон бусад холбогдох баримт бичгүүдийн хувийг бэлэн байлгана.

(b) Өргөдөл гаргагч нь зүйл(а)-д заасан бүх баримт бичгүүдийг хянах зорилгоор дараах зүйлсийг тусгасан журмыг тогтооно -

- (1) баримт бичгийг тараахаас өмнө зохих ажилтандүн шинжилгээ хийж, зөвшөөрөл олгодог байх; болон
- (2) үйл ажиллагааны зааварт тусгагдсан нисэхийн мэдээллийн үйлчилгээнүүдийг үзүүлэхэд шаардлагатай баримт бичгүүдийг хүчинтэй хувилбараар нь бэлэн байлгах; болон

- (3) хүчингүй болсон баримт бичгүүдийг тараах буюу хэрэглэхээс сэргийлж тухай бүрт нь устгах; болон
- (4) баримт бичгүүдэд оруулах өөрчлөлтийг зохих ажилтан хянаж, зөвшөөрөл олгодог байх; болон
- (5) хуучирсан хувилбарыг хэрэглэхээс сэргийлж баримт бичгийн бүрэлдэхүүн хэсэгбүрийн хүчин төгөлдөр хувилбарыг ялган танихад хялбар байлгах.

175.59 Мэдээлэл болон өгөгдөл цуглуулах

(a) Нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ хүссэн өргөдөл гаргагч нь үйл ажиллагааны заавартаа тусгагдсан нисэхийн мэдээллийн үйлчилгээнүүдэд шаардлагатай мэдээлэл болон өгөгдлийг цуглуулах болон **эмхлэн цэгцлэх** журмуудыг тогтооно.

(b) Эдгээр журмуудад **дараах зүйлсийг** тусгасан байна -

- (1) Монгол Улсын агаарын навигацийн тогтолцоонд үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудаас холбогдох мэдээллийг хүлээн авдаг байх; болон
- (2) Дараах олон улсын агаарын хөлгийн операторуудад шаардлагатай мэдээллийг бусад Улсуудын нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагуудаас авдаг байх –
 - (i) Шаардлагагүй
 - (ii) Монгол Улсаас эхлэх олон улсын агаарын замуудаар нислэг үйлддэг; болон
- (3) зүйл (b)(1) болон (2)-т заасан мэдээлэгч байгууллагуудаас мэдээллээр цаг тухайд нь хангаж байх талаар харилцан тохиролцсон байх; болон
- (4) зүйл (b)(1)-д заасан мэдээлэгч байгууллагаас хүлээн авсан мэдээлэл нь тухайн байгууллагаас томилогдсон, мэдээллийн үнэн зөвд хариуцлага хүлээх албан тушаалтнаар баталгаажуулагдсан байх.

(c) Зүйл (b)-д зааснаас гадна, NOTAM мэдээний үйлчилгээтэй холбоотой журмуудад ирүүлсэн түүхий мэдээлэл нь NOTAM мэдээгээр зарлагдах бол хүчин төгөлдөр байх хугацааг 3 сараас дээшгүй байхаар тусгасан байна.

175.61 Нисэхийн мэдээллийг хэвлэх

(a) Нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ хүссэн өргөдөл гаргагч нь үйл ажиллагааны заавартаа тусгагдсан үйлчилгээнүүдэд шаардлагатай нисэхийн мэдээллийг шалгах, зохицуулах, **боловсруулах**, хэвлэх ба тараах журмуудыг тогтооно.

(b) Өргөдөл гаргагч нь зүйл (a)-ын дагуу тогтоосон журмуудад дараах зүйлсийг тусгасан байна—

- (1) **дүрэм 175.59**-д заасны дагуу хүлээн авсан мэдээллийг хэвлэн гаргахаас өмнө боломжит мэдээлэл ашиглан түүний үнэн зөвийг баталгаажуулан шалгах; болон
- (2) **дүрэм 175.59**-д заасны дагуу хүлээн авсан мэдээллийг дараах шаардлагад нийцүүлэн боловсруулах, үнэн зөв хэвлэх болон тараах -
 - (i) мэдээллийн үйл ажиллагааны ач холбогдолд тохирох **форматанд** оруулах; болон
 - (ii) боломжтой бол D, E эсхүл F бүлгийн дагуу; болон
 - (iii) мэдээллийг ашиглах нөхцөл байдалд тохирсон **форматаар** байх.
- (3) зүйл (b)(4)-д зааснаас бусад тохиолдолд, тогтмол хэвлэл болон урт хугацаатай, түр шинж чанартай хэвлэл нь өргөдөл гаргагчийн нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээгээр олгогдсон эрхийн дагуу хэвлэгдсэнийг илэрхийлсэн тэмдэглэгээтэй байх; болон
- (4) **дүрэм 175.59(b)(2)**-т заасны дагуу бусад улсын нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагуудаас авсан нисэхийн мэдээллийг тараах тохиолдолд тухайн улсын эрх бүхий байгууллагаас хүлээн авсан гэдгийг тодорхойлох тэмдэглэгээтэй байх; болон
- (5) **дүрэм 175.59(b)(4)**-т заасны дагуу үнэн зөвийг баталгаажуулаагүй мэдээллийг тараах тохиолдолд уг мэдээллийг баталгаажуулаагүйг тодорхой тэмдэглэсэн байх; болон

- (6) хэвлэгдсэн тогтмол шинж чанартай мэдээлэлд өөрчлөлт оруулах тохиолдолд тухайн өөрчлөлтийг хэвлэхээс өмнө холбогдох бусад мэдээлэгчидтэй зохицуулалт хийсэн байх; болон
 - (7) дуусах хугацаа нь тодорхойгүй хэвлэгдсэн түр шинж чанартай мэдээллийг мэдээлэгчээс шаардлагатай үед нь цуцлах эсхүл сунгах арга хэмжээ авах боломжийг олгохын тулд зохих хугацаанд нь дүн шинжилгээ хийх; болон
 - (8) нисэхийн мэдээллийг Монгол болон/эсхүл Англи хэл дээр хэвлэх;болон
 - (9) газрын орны нэрнүүдийг орон нутгийн хэрэглээний дагуу бичих, шаардлагатай тохиолдолд Латин үсгээр галиглах; болон
 - (10) хэмжих нэгжүүд нь MNS 6478:2014 стандартад нийцсэн байх; болон
 - (11) хэвлэгдсэн нисэхийн мэдээлэлд Дүрэм 1-д нийцсэн товчлолуудыг дараах тохиолдолд хэрэглэнэ -
 - (i) хэрэглэхэд тохиромжтой; болон
 - (ii) хэрэглэх нь мэдээллийг тараахад хялбар болгожбайвал; болон
 - (12) хэвлэгдсэн аливаа нисэхийн мэдээллийг бусадулсыннисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагуудаас хүсэлт гаргасан тохиолдолд нэн даруй дамжуулах; болон
 - (13) дор дурьдсан хэрэглэгчдийн үйл ажиллагааны шаардлагад тохирох хэлбэрээр нисэхийн мэдээллийг бэлэн байлгах -
 - (i) нисэх багийн гишүүд, нислэгийн үйл ажиллагаа хариуцсан ажилтнуудболон нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээний байгууллагууд; болон
 - (ii) нислэгийн мэдээллийн үйлчилгээ хариуцсаннислэгийн хөдөлгөөний үйлчилгээний нэгжүүд.
- (c) Өргөдөл гаргагч нь НМЭ-ийн үйлчилгээний журмуудад зүйл(b)-д зааснаас гадна дараах зүйлсийг тусгасан байна –
- (1) нислэгийн зургууд, НМЭ-ийн Өөрчлөлт болон НМЭ-ийн Нэмэлтээр хэвлэгдэх үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой мэдээллийг AIRAC-ийн тогтолцооны дагуу хэвлэх;болон
 - (2) AIRAC-ийн тогтолцооны дагуу хэвлэгдэх мэдээлэл нь AIRAC гэсэн тэмдэглэгээтэй байх; болон

- (3) AIRAC-ийн тогтолцооны дагуу хэвлэгдсэн мэдээллийг түгээхдээ уг мэдээллийн хүчинтэй болох хугацаанаас хамгийн багадаа 28 хоногийн өмнө хэрэглэгчид хүрсэн байхаар тооцох; болон
- (4) зарлагдах нөхцөл байдал нь түр шинж чанартай бөгөөд урт хугацаагаар үргэлжлэхээс бусад тохиолдолд AIRAC-ийн тогтолцооны дагуу хэвлэгдсэн мэдээлэлд хүчин төгөлдөр болох өдрөөс хойш хамгийн багадаа 28 хоногийн дотор өөрчлөлт оруулахгүй байх; болон
- (5) NOTAM мэдээг орлуулахаар НМЭ-ийн Нэмэлт хэвлэсэн тохиолдолд тухайн NOTAM мэдээний серийн дугаарыг НМЭ-ийн Нэмэлтэнд оруулж өгөх; болон
- (6) AIRAC-ийн тогтолцооны дагуу НМЭ-ийн Өөрчлөлт эсхүл НМЭ-ийн Нэмэлт хэвлэх тохиолдолд үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой мэдээллүүд, хүчин төгөлдөр болох өдөр болон өөрчлөлт эсхүл нэмэлт бүрийн дугаарыг багтаасан NOTAM мэдээ зарлах. Энэхүү NOTAM мэдээ нь -
 - (i) тухайн өөрчлөлт эсхүл нэмэлттэй ижил хүчин төгөлдөр болох өдөртэй байх; болон
 - (ii) 14 хоногийн хугацаанд хүчинтэйхэвээр байх;
- (7) AIRAC-ийн хүчин төгөлдөр болох өдөр хэвлэгдэх мэдээлэл байхгүй тохиолдолд NIL гэсэн тэмдэглэгээтэй зарлах; болон
- (8) НМЭ-ийн Өөрчлөлт эсхүл НМЭ-ийн Нэмэлтээр хэвлэгдсэн мэдээлэл нь тухайн өөрчлөлт эсхүл нэмэлтийн хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө хүчинтэй болох тохиолдолд NOTAM мэдээгээр зарлах.

175.63 Хэвлэгдсэн мэдээллийн алдааг залруулах

- (a) Нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээхүссэн өргөдөл гаргагч нь гэрчилгээгээр олгогдсон эрхийн дагуу хэвлэсэн нисэхийн мэдээлэлд илэрсэн аливаа алдааг бүртгэх, шинжлэн шалгах, залруулах болон илтгэх журмуудыг тогтооно.
- (b) Эдгээр журмуудад дараах зүйлсийг тусгасан байна -
 - (1) илэрсэн алдааны үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөнөөс хамаарч хамгийн тохиромжтой арга замаар залруулах; болон
 - (2) дахин хэвлэсэн мэдээлэлд залруулгыг тодорхой зааж өгөх; болон
 - (3) алдааны эх сурвалжийг тодорхойлж, боломжтой бол устгах; болон
 - (4) зарласан мэдээлэлд **зөрчил** гарсан тохиолдолд Дүрэм 12-ын дагуу Даргад мэдэгддэг байх.

175.65 Бүртгэлүүд

(a) Нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээхүссэн өргөдөл гаргагч нь үйл ажиллагааны заавартаа тусгагдсан нисэхийн мэдээллийн үйлчилгээнүүдэд шаардлагатай бүртгэлүүдийг тодорхойлох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, шинэчлэх болон устгах журмуудыг тогтооно.

(b) Эдгээр журмуудад дараах зүйлсийг тусгасан байна–

- (1) хүлээн авсан болон түгээсэн бүх нисэхийн мэдээллийг гялгаж танихад хялбар дэс дугаар болон огноотой болгосоноос гадна холбогдох нэмэлт мэдээллүүдийг үүнтэй ижил байдлаар бүртгэж шаардлагатай газарт нь баталгаажуулах боломжтой бүртгэл хөтлөх; болон
- (2) өргөдөл гаргагчаас нисэхийн мэдээллийг шалгах, боловсруулах болон хэвлэх эрх олгосон ажилтан бүр бүртгэл хөтлөх; болон
- (3) энэ дүрмийн 175.63-д заасан журмуудын дагуу алдааг залруулсан тохиолдол бүрт бүртгэл хөтлөх; болон
- (4) (хүчингүй болгосон)
- (5) бүх бүртгэлүүд гаргацтай, арилахгүйгээр тод байх; болон
- (6) NOTAM мэдээ, НМЭ-ийн Нэмэлт болон Нисэхийн мэдээллийн цувралуудыг хүчингүй болсоноос хойш 30 хоног, бусад бүх бүртгэлүүдийг хамгийн багадаа 5 жил хадгалах.

175.67 Аюулгүй ажиллагааны удирдлага

Нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ хүссэн өргөдөл гаргагч нь дүрэм 100.3-д нийцсэн аюулгүй ажиллагааны тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх болон хадгалах үүрэгтэй.

175.69 Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааны заавар

(a) Нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ хүссэн өргөдөл гаргагч нь дараах зүйлсийг агуулсан үйл ажиллагааны зааврыг даргад хүргүүлнэ -

- (1) үйл ажиллагааны заавар болон түүнд багтсан аливаа гарын авлагууд нь дараах шаардлагыг хангасан болохыг бататгаж өргөдөл гаргагчийн байгууллагын өмнөөс удирдах ажилтан гарын үсэг зурсан батламж -
 - (i) байгууллагыг бүрэн тодорхойлж, энэ дүрэмд байнга нийцсэн үйл ажиллагаа явуулах арга хэлбэр болон арга замуудыг харуулсан; болон
 - (ii) тэдгээрийг тасралтгүй хэрэгжүүлж, мөрдөх; мөн

(1A) энэ дүрмийн 175.67-д заасан аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоотой холбогдуулан -

- (i) **дүрэм 100.3**-д шаардсанбүхбаримт бичгүүд; болон
 - (ii) нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ **сунгуулахаар өргөдөл гаргаагүй** өргөдөл гаргагчийн хувьд, аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх төлөвлөгөөгаргах; болон
- (2) энэ дүрмийн 175.51(a)(1) болон(2)-т заасан удирдах ажилтан болонажилтнуудын албан тушаал ба нэр; болон
- (3) энэ дүрмийн 175.51(a)(1) ба (2)-т заасан удирдах ажилтан болон ажилтнуудын хүлээх үүрэг хариуцлагууд -
- (i) өөрийн байгууллагыг төлөөлөн **Дарга эсхүл Эрх бүхий байгууллагатай** шууд харьцах хариуцлага хүлээсэн асуудлууд; болон
 - (ii) аюулгүй ажиллагааны удирдлагатай холбоотой хүлээхүүрэгхариуцлагууд; болон
- (4) энэ дүрмийн 175.51(a)(1) болон(2)-т заасан удирдах ажилтан болон ажилтнуудын үүрэг, хариуцлагын холбоосыг харуулсан байгууллагын бүдүүвч; болон
- (5) зүйл(a)(6)-д тусгасан нисэхийн мэдээллийн үйлчилгээ бүрийг эрхлэн явуулах ажилтнуудын зохион байгуулалтын бүтэц; болон
- (5A) байгууллага дотор аюулгүй ажиллагаатай холбоотой хүлээхүүрэгхариуцлагын холбоосыг харуулсан мэдээлэл; болон
- (6) гэрчилгээний дагуу үзүүлэх нисэхийн мэдээллийн үйлчилгээнүүдийн жагсаалт;болон
- (7) нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээний хувьд, энэ дүрмийн 175.55-д заасан газарзүйн бүс, аэродром болон агаарын замуудын дэлгэрэнгүй мэдээлэл; болон
- (8) энэ дүрмийн 157.103(b)(1) болон 175.105(1)-д заасан нэгжүүдийн байршил болон хаягийн мэдээлэл; болон
- (9) энэ дүрмийн 175.57(a)(1)-д заасан хэвлэх нисэхийн мэдээллийн форматболон стандартуудын мэдээлэл; болон
- (10) дараах зүйлстэй холбогдуулан өргөдөл гаргагчийн тогтоосон журмуудын мэдээлэл -
- (i) ажилтнуудын ур чадвар; болон
 - (ii) баримт бичгийн хяналт; болон

- (iii) мэдээлэл цуглуулах; болон
 - (iv) нисэхийн мэдээллийг хэвлэх; болон
 - (v) хэвлэгдсэн мэдээллийн алдааг залруулах; болон
 - (vi) бүртгэлийг тодорхойлох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, шинэчлэх болон устгах; болон
- (11) үйл ажиллагааны зааврыг хянах, өөрчлөх болон тараах журмууд.
- (b) Өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны зааврыг Дарга баталсан байна.

С бүлэг — Үйл ажиллагаанд тавигдах шаардлагууд

175.101 Байнгын нийцэл

Нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч бүр нь -

- (1) үйл ажиллагааны зааврын хүчин төгөлдөр, **бүрэн бүтэн** нэгээс доошгүй хувийг үйл ажиллагааны заавартаа тусгасан нэгж бүрт байлгах; болон
- (2) үйл ажиллагааны заавартаа тусгасан бүх журам болон стандартуудыг мөрдөж ажиллах; болон
- (3) ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай үйл ажиллагааны зааврын зохих хэсгүүдийг тухайн ажилтны ажлын байранд бэлэн байлгах; болон
- (4) гэрчилгээжүүлэлттэй холбоотой энэ дүрмийн Б бүлэгт заасан стандарт болон шаардлагуудыг мөрдөн ажиллах; болон
- (5) ИНЕГ175/01 маягтанд заасан байгууллагын хаяг, утасны дугаар эсхүл факсын дугаарт өөрчлөлт орох тохиолдолд Даргад 28 хоногийн дотор мэдэгдэх.

175.103 НМЭ-ийн үйлчилгээ

(a) НМЭ-ийн үйлчилгээний төрлөөр нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч нь дараах бүтээгдэхүүнийг хэвлэх үүрэгтэй -

- (1) D бүлгийн дагуу Монгол Улсын НМЭ; болон
- (2) энэ дүрмийн 175.155-ын дагуу НМЭ-ийн Өөрчлөлт; болон
- (3) **дүрэм 175.157**-д заасны дагуу дараах төрлийн мэдээллийг НМЭ-ийн Нэмэлтээр зарлана
 - (i) 3 сар буюу түүнээс дээш хугацаатай түр шинж чанартай өөрчлөлтүүд; болон

- (ii) их хэмжээний текст эсхүл график агуулсан, 3 сараас бага хугацаатай мэдээлэл; болон
 - (4) Ебүлгийн дагуу НМЦ;
 - (5) ICAO-ийн Хавсралт 4-ийн дагуу нислэгийн зургууд.
- (b) Гэрчилгээ эзэмшигч нь зүйл(а)-д зааснаас гадна -
- (1) бусад улсын нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагуудтай Монгол Улсыг төлөөлөн харилцаж NOTAM мэдээнээс бусад Нисэхийн мэдээллийн нэгдсэн багцийг солилцох нэгжийг томилно; болон
 - (2) бүтээгдэхүүнийг нийлүүлэхтэй холбоотой зардлыг төлүүлсэний дагуу Монгол Улсын НМЭ, НМЭ-ийн Өөрчлөлт, НМЭ-ийн Нэмэлт болон НМЦ-ыг авахаар хүсэлт гаргасан хүнболгонд нийлүүлнэ;
 - (3) энэ дүрмийн 175.61(c)(3)-ын дагуу Монгол Улсын НМЭ, НМЭ-ийн Өөрчлөлт, НМЭ-ийн Нэмэлт, нислэгийн зургууд болон НМЦ-ыг тараах тогтолцоог бий болгоно; болон
 - (4) Монгол Улсын НМЭ-ийн нэг хэсэг болж хэвлэгдсэн нислэгийн зураг бүр нь нислэгийн зургийн зохих стандартад нийцсэн байхыг бататгана; болон
 - (5) дор дурьдсанаас бусад тохиолдолд энэ дүрмийн 175.59 (b)(1)-д заасны дагуу мэдээлэгчдээс ирсэн бүх нисэхийн мэдээлэлд зохицуулалт хийнэ -
 - (i) NOTAM мэдээ яаралтай зарлах шаардлагатай, үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой мэдээлэл; болон
 - (ii) зөвхөн NOTAM мэдээгээр зарлах шаардлагатай, 3 сараас бага хугацаатай түр шинж чанартай мэдээлэл.

175.105 NOTAM мэдээний үйлчилгээ

NOTAM мэдээний үйлчилгээний төрлөөр нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч нь -

- (1) Монгол Улсын олон улсын NOTAM-ын нэгжийг томилно; болон
- (2) олон улсын NOTAM-ын нэгжийг 24 цагаар ажиллуулна; болон
- (3) бусад олон улсын NOTAM-ын нэгжтэй зөвшилцсөний үндсэн дээр NOTAM мэдээ солилцоно; болон
- (4) дараах зүйлсийг бататгана—
 - (i) Олон улсын NOTAM-ын нэгж нь AFTN сүлжээнд холбогдсон байх; болон

- (ii) AFTN сүлжээний холболт нь хэвлэх боломжтой хэлбэрээр байх; болон
 - (iii) Олон улсын NOTAM-ын нэгж нь цахилгаан холбоогоор тараагддаг NOTAM мэдээг хүлээн авах болон тараах зохих тоног төхөөрөмжтэй байх; болон
- (5) энэ дүрмийн 175.59-д заасны дагуу хүлээн авсан мэдээллийг NOTAM мэдээгээр зарлах шаардлагатай тохиолдолд E бүлгийн дагуу нэн даруй NOTAM мэдээ зарлана; мөн
- (6) хүчинтэй NOTAM мэдээнүүдийн хяналтын жагсаалтыг AFTN сүлжээгээр хоорондын зай нь 1 сараас илүүгүйбайхаартаараана.

175.107 Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ

(a) Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээний төрлөөр нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн үйл ажиллагаанд оролцогч ажилтан болон нисэх багийг дараах нисэхийн мэдээллээр хангана -

- (1) агаарын навигацийн аюулгүй ажиллагаа, тогтмолжилт болон үр ашигт чухал ач холбогдолтой; болон
- (2) гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны зааварт тусгасан газарзүйн бүс, аэродромуудболон агаарын замуудтай холбоотой.

(b) Зүйл (a)-д заасан нисэхийн мэдээлэл нь дараах агуулгатай байна -

- (1) Хүчин төгөлдөр NOTAM мэдээний бүрдэлболон бусад чухал шаардлагатай мэдээллийг энгийн бичвэр хэлбэрээр агуулсан НӨМ-ийн товхимол; болон
- (2) Нисэхийн мэдээллийн нэгдсэн багцын холбогдох элементүүд; болон
- (3) холбогдох газрын болон нислэгийн зургууд; болон
- (4) нисэн гарах аэродромд хамааралтай тухайн цаг үеийн дараах мэдээллүүд:
 - (i) маневрлах талбай буюу түүний зэрэгцээ хийж буй барилгын эсхүл засварын ажил;
 - (ii) хөөрч буух зурвасболонявгалах замын гадаргуугийн эвдрэлгарсан хэсгүүдийг оролцуулан маневрлах талбайнтэмдэглэгээтэй эсхүл тэмдэглэгээгүйаль нэг тэгш бус хэсэг;
 - (iii) хөөрч буух зурвас болон явгалах зам дээрцас, мөс эсхүл усбайгаа эсэх, тэдгээрийн гүнболон гадаргуугийн үрэлтийн коэффициентэд нөлөөлөх байдал;

- (iv) хөөрч буух зурвас эсхүл явгалах зам дээр эсхүл түүний хажууд **хунгарласан эсхүл овоолсон** цас;
- (v) явгалах зам дээр эсхүл түүний хажууд зогсож байгаа агаарын хөлөг эсхүл бусад объект;
- (vi) шувуудаас шалтгаалан үүссэн гэх мэт бусад түр зуурын аюулууд;
- (vii) ойртолт, босго, хөөрч буух зурвас, явгалах зам болон саадын гэрлүүдийг оролцуулан аэродромын гэрлэн системд хэсэгчлэн эсхүл бүхэлд нь болон маневрлах бүсийн ажилгүй хэсгийг анхааруулах гэрэл болон аэродромын цахилгаан хангамжид гарсан гэмтэл саатал эсхүл тогтмол бус ажиллагаа;
- (viii) ILS болон маркерууд, PSR, SSR, VOR, NDB, VHF аэромобил сувгууд, RVR хэмжих ажиглалтын систем болон нөөц цахилгаан хангамж гэх мэт агаарын навигацийн тоног төхөөрөмжүүдэд гарсан гэмтэл саатал, тогтмол бус ажиллагаа эсхүл үйл ажиллагааны нөхцөл байдалд гарсан өөрчлөлт;

(c) Нисэхийн мэдээллийн үйлчилгээний нислэгийн өмнөх мэдээллийн төрлөөр гэрчилгээ эзэмшигч нь үйл ажиллагааны зааварт тусгагдсан аэродромуудад нислэгийн дараах илтгэх хуудсыг нисэх багаар бөглүүлэх талаар заалт оруулна.

(d) Нисэхийн мэдээллийн үйлчилгээний нислэгийн өмнөх мэдээллийн төрлөөр гэрчилгээ эзэмшигч нь зүйл(с)-д заасны дагуу агаарын навигацийн тоног төхөөрөмжүүдийн нөхцөл байдал болон үйл ажиллагаатай холбогдуулан нисэх багаас ирүүлсэн аливаа мэдээллийг нислэгийн дараах илтгэх хуудсаартухайн навигацийн тоног төхөөрөмжийг хариуцсан байгууллагад дамжуулна.

175.109 Гэрчилгээ эзэмшигч байгууллагад гарсан өөрчлөлт

(a) Нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч нь байгууллагын үйл ажиллагаа, эрхлэх үйлчилгээ болон бүтцэд өөрчлөлт орсон үед үйл ажиллагааны зааварт тухайбүр оруулна.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь үйл ажиллагааны зааварт оруулж байгаа өөрчлөлтийгэнэ дүрмийн холбогдох шаардлагууд болон үйл ажиллагааны зааварт оруулах журамд нийцсэн байхыг бататгана.

(c) Гэрчилгээ эзэмшигч нь үйл ажиллагааны зааварт өөрчлөлт орсон даруйд өөрчлөлтийн хувийг Даргад ирүүлнэ.

(d) Гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны зааварт дараах өөрчлөлтүүдийн аль нэгийг оруулах тохиолдолд Даргад урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авсан байна:

- (1) удирдах ажилтан:

- (2) удирдах ажилтнууд;
- (3) гэрчилгээ эзэмшигчийн үзүүлэх нисэхийн мэдээллийн үйлчилгээнүүд;
- (4) гэрчилгээгээр олгогдсон эрхийн дагуу хэвлэгдэх нисэхийн мэдээллийн формат ба стандартууд;
- (5) аюулгүй ажиллагааны тогтолцоотой холбоотой томоохон өөрчлөлт орсон бол;

(e) Даргазүйл(d)-д заасан аливаа өөрчлөлтийг оруулах эсхүл мөрдөх явцад үйл ажиллагаа явуулах нөхцлийг тусгайлан тогтоож өгч болно.

(f) Гэрчилгээ эзэмшигч ньзүйл(e)-ийн дагуу Даргаас тогтоосон аливаа нөхцлийг дагаж мөрдөх үүрэгтэй.

(g) Энэ дүрэмд дурьдагдсан аливаа өөрчлөлт нь гэрчилгээнд өөрчлөлт оруулах шаардлага бий болгосон тохиолдолд гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээгээ Даргад нэн даруй хүргүүлнэ.

(h) Гэрчилгээ эзэмшигч нь Даргын нисэхийн аюулгүй ажиллагаанд шаардлагатай гэж үзсэн өөрчлөлтийг үйл ажиллагааны заавартаа оруулна.

175.111 Хүчингүй болгосон

D бүлэг — Монгол Улсын Нисэхийн мэдээллийн эмхтгэл

175.151 Монгол Улсын НМЭ-ийн агуулга

(a) Монгол Улсын НМЭ ньдараах зүйлстэй холбоотой хүчин төгөлдөр мэдээлэл, өгөгдөл болон нислэгийн зургуудыг агуулсан байна -

- (1) **Монгол** НМР-д агаарын навигацид тавигдах зохицуулалтын болон агаарын зайн шаардлагууд; болон
- (2) Монгол Улсад ирэх болон явах олон улсын нислэгүүдийн агаарын навигацид үзүүлэх Монгол Улсын үйлчилгээ болон тоног төхөөрөмжүүд; болон
- (3) Монгол Улсын Нисэхийн мэдээллийн районд үзүүлэх агаарын навигацийг дэмжих үйлчилгээ болон тоног төхөөрөмжүүд;болон
- (4) **Дүрэм 139-ийн дагуу**олгосон аэродромын гэрчилгээний дагуу үйл ажиллагаа явуулж буй аэродромууд.

(b) Монгол Улсын НМЭ ньдараах тохиолдолд аэродромын гэрчилгээгүй аэродромуудтай холбоотой хүчин төгөлдөр мэдээлэл, өгөгдөл болон нислэгийн зургуудыг агуулж болно -

- (1) аэродромын оператор нь НМЭ-ийн үйлчилгээний төрлөөр нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ эзэмшигчийг тухайн аэродромтой холбоотой шаардлагатай өгөгдөл болон мэдээллээр хангасан; болон
 - (2) аэродромын оператор нь хангасан өгөгдөл ба мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр байдалд хариуцлага хүлээх; болон
- (с) Монгол Улсын НМЭ нь дараах зүйлсийг зохих хэсгүүддээ агуулсан байна-
- (1) Монгол Улсын НМЭ-д орсон агаарын навигацийн тоног төхөөрөмж, үйлчилгээ болон журмуудад хариуцлага хүлээх гэрчилгээжсэн байгууллагуудын талаарх мэдээлэл; болон
 - (2) эдгээр үйлчилгээ болон тоног төхөөрөмжүүдийн ашиглалтанд тавигдах ерөнхий нөхцлүүд;
 - (3) Конвенцийн 38-р зүйлийн дагуу Даргын **бөглөсөн** ICAO-ийн стандарт, зөвлөмж ба журмуудаас зөрүүтэй байдлуудын жагсаалт; болон
 - (4) ICAO-ийн стандарт, зөвлөмж болон журмуудаар зөвшөөрсөн, сонголттойгоор хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагааны Монгол Улсад мөрдөгдөж буй тусгай стандарт, зөвлөмж болон журмын хураангуй.

175.153 Монгол Улсын НМЭ-д тавигдах шаардлагууд

- (а) Монгол Улсын НМЭ-ийг бүрдүүлж буй хэвлэл бүрт -
- (1) тухайн хэвлэлийн **зорилго**, хамрах газарзүйн бүс болон уг хэвлэл нь Монгол Улсын НМЭ-ийн нэг хэсэг болохыг заасан байна; болон
 - (2) хуудасны дугаарлалт бүхий агуулгатай байх болон хуудсууд нь ойлгомжтой дугаарлагдсан, **бие даасан байна**; болон
 - (3) дараах зүйлсийг зааж өгсөн байна –
 - (i) НМЭ-ийн үйлчилгээний төрлөөр нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ эзэмшигчээс хэвлэн гаргасан; болон
 - (ii) Даргаас олгосон гэрчилгээний бүрэн эрхийн дагуу хэвлэгдсэн; болон
 - (4) давтагдсан мэдээлэлгүй байх болон хэрэв зайлшгүй давтагдах шаардлагатай бол нэг тоног төхөөрөмж, үйлчилгээ эсхүл журмын давтагдсан мэдээллүүд нь өөр хоорондоо зөрүүгүй байх; болон
 - (5) огноотой байх болон хэрвээ салдаг хуудастай тохиолдолд хуудас бүр нь огноотой байна. Огноо нь тухайн нисэхийн мэдээлэл хүчин төгөлдөр болох өдөр, сарыг нэрээр нь болон жилийг агуулсан байна.

- (6) НМЭ-ийн **давтамжтайгаар** Өөрчлөлтөөр эсхүл тогтсон шинэчлэгддэг байна; болон
- (7) баталгаажуулагдаагүй мэдээллийн үнэн зөв байх **магадлалын түвшинг** тодорхой заасан байна.
- (b) Салдаг хуудастай хэвлэл нь -
- (1) хуудас бүр дээр тухайн хамаарах хэвлэл болон Монгол Улсын НМЭ-ийн нэг хэсэг болохыг заасан байна; болон
- (2) Хяналтын жагсаалттай байна. Энэхүү хяналтын жагсаалт нь -
- (i) тухайн хэвлэлд багтсан хуудас эсхүл нислэгийн зураг бүрийн хүчинтэй огноо болон хуудасны дугаар эсхүл зургийн нэрийг агуулна; болон
- (ii) НМЭ-ийн Өөрчлөлт бүртэй хамт тараагдана; болон
- (iii) хамаарах хэвлэлийг заана; болон
- (iv) зүйл (a)(5)-д заасны дагуухуудасны дугаар болон огноотой хэвлэгдэнэ.

175.155 НМЭ-ийн Өөрчлөлтүүдэд тавигдах шаардлагууд

НМЭ-ийн Өөрчлөлт бүр нь дараах шаардлагыг хангана-

- (1) хэвлэгдсэн мэдээлэлд орсон өөрчлөлт болон дахин хэвлэсэн хуудас дээрх бүх шинэ мэдээллүүдийн ялгааг тодорхой заасан **таних тэмдэг** эсхүл тайлбартай байх; болон
- (2) хуанлийн жилд үндэслэсэн, дараалсан дугаартай байх.

175.157 НМЭ-ийн Нэмэлтүүдэд тавигдах шаардлагууд

- (a) НМЭ-ийн Нэмэлт бүр нь хуанлийн жилд үндэслэсэн, дараалсан дугаартай байна.
- (b) НМЭ-ийн Нэмэлтийн хуудсуудын аль нэг хэсэгт хүчинтэй мэдээлэл агуулагдаж байвал НМЭ-д хавсаргагдсан хэвээр байна.
- (c) Хүчинтэй НМЭ-ийн Нэмэлтийн хяналтын жагсаалтыг нэг сараас илүүгүй хугацаанд эсхүл НМЭ-ийн Нэмэлт бүртэй хамт тараана. Хяналтын жагсаалтыг НМЭ-ийн Нэмэлттэй адил тараана.

Е бүлэг — Нисэхийн мэдээллийн цувралууд

175.201 Нисэхийн мэдээллийн цувралд тавигдах шаардлагууд

- (a) НМЦ бүр нь -
- (1) хэвлэмэл байдлаар түгээгддэг байна; болон

- (2) хуанлийн жилд үндэслэсэн, дараалсан дугаартай байна
- (b) Олон улсын агаарын хөлгийн операторуудад нөлөөлөх НМЦ-ыг НМЭ-тэй адил тараана.
- (c) НМЦ-ыг нэгээс илүү сериэртараадаг тохиолдолд сери бүр нь ялгагдахүсгэн тэмдэглэгээтэй байна.
- (d) Хүчинтэй НМЦ-ын хяналтын жагсаалтыг хамгийн багадаа жилд нэгээс доошгүй удаа НМЦ-аар хэвлэн түгээнэ.

F бүлэг — NOTAM мэдээ

175.251NOTAM мэдээнд тавигдах шаардлагууд

- (a) NOTAM мэдээ тус бүр ньолон улсынNOTAM-ийн нэгжээс олгосон А эсхүл С серийн дугаартай байна. Серийн бүрийн доторх дугаарлалт ньхуанлийн жилд үндэслэсэн болон дараалсан байна.
- (b) хэрэглэх боломжгүй
- (c) хэрэглэх боломжгүй
- (d) NOTAM мэдээ бүр нь зөвхөн нэг зүйлийн тухай товч, тодорхой, өөр баримт бичгээс лавлаж харах шаардлагагүй байна.
- (e) NOTAM мэдээ нь Монгол УлсынНМЭ-ийн өөрчлөлт эсхүл НМЭ-ийн Нэмэлт гаргах шаардлагатай мэдээлэл агуулж байвал тухайн НМЭ эсхүл НМЭ-ийн Нэмэлтийн хэсгийн **лавлагааг**NOTAM мэдээнд оруулна.
- (f) Өмнөх NOTAM мэдээг цуцалж эсхүл орлуулж NOTAM мэдээ зарлах тохиолдолд өмнөх NOTAM мэдээний дугаарыг зааж өгнө.
- (g) NOTAM мэдээнд алдаа илэрсэн тохиолдолд тухайн NOTAM мэдээг **залруулах**NOTAM мэдээ зарлана.
- (h) NOTAM мэдээний текстэнд орсон байршил илтгэгч 4 үсгийн код нь ICAO-оос батлагдсан байна.
- (i) Байршил илтгэгчийг товчилсон хэлбэрээр ашиглаж болохгүй.
- (j) Тухайн газар нь байршил илтгэгч 4 үсгийн кодгүй бол NOTAM мэдээний текстэнд газрын нэрийг энэ дүрмийн 175.61(b)(9)-д заасны дагуу оруулна.
- (k) Энэ дүрмийн 175.105(6)-д заасан NOTAM мэдээний хяналтын жагсаалт нь -
- (1) хамгийн сүүлд хэвлэгдсэн НМЭ-ийн Өөрчлөлт, НМЭ-ийн Нэмэлт болон олон улсын тараасан НМЦ-уудын дугаарыг агуулна; болон
 - (2) дурьдаж байгаа NOTAM мэдээний серитэй адил тараагдах bachecklist гэж тодорхой тэмдэглэсэн байна.

(l) А серийн NOTAM мэдээ бүрийг олон улсад тараахад тохиромжтой хэлбэрээр **бэлтгэх ба боловсруулна.**

175.253 NOTAM мэдээг түгээх

(a) NOTAM мэдээ бүрийг -

- (1) **боломжтой тохиолдолд аль болох** цахилгаан холбооны нэг мэдээ хэлбэрээр дамжуулна; болон
- (2) тухайн мэдээлэл нь: үйл ажиллагаанд нь шууд ач холбогдолтой болон өөр ямар нэгэн хэлбэрээр хамгийн багадаа 7 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэх боломжгүй хүлээн авагчдад тараадаг байна.

(b) С серийн NOTAM мэдээг Монгол Улс дотор тараана.

(c) А серийн NOTAM мэдээнүүдийг Монгол Улс дотор болон энэ дүрмийн 175.105(3)-д заасны дагуу харилцан зөвшилцсөн бусад олон улсын NOTAM-ийн нэгжүүдэд тараана.

(d) NOTAM мэдээг аль болох AFTN сүлжээгээр тараана.

(e) Энэ дүрмийн 175.105(3)-ын дагуу харилцан зөвшилцсөний үндсэн дээр солилцох NOTAM мэдээг AFTN сүлжээнээс өөр хэрэгслээр илгээх тохиолдолд тухайн мэдээний өмнө илгээсэн огноо, цагийг 6 оронтой тоогоор болон мэдээ илгээгчийн хаягийг тусгасан байна.

(f) Энэ дүрмийн 175.105(3)-ын дагуу бусад олон улсын NOTAM-ын нэгжүүдтэй зөвшилцсөн тохиолдолд AFTN сүлжээг ашиглан NOTAM мэдээг тараах тогтолцоог урьдчилан бүрдүүлнэ.

G бүлэг – Шилжилтийн үеийн заалтууд *Дүрмийн 175.253 заалтын дараа 175.301 заалт орсон/*

175.301 Нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч болон өргөдөл гаргагчдын шилжилтийн үе

(a) Энэ дүрэм нь дараах байгууллагад хамаарна -

- (1) нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч:
- (2) нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ хүссэн өргөдөл гаргагч.

(b) 2018 оны 2-р сарын 1-ээс өмнө, энэ дүрэм хамаарах байгууллага нь -

- (1) дараах шаардлагыг биелүүлэх шаардлагагүй -

- (i) аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтны оронд тухайн байгууллагад дотоод чанар хангалтхариуцсан удирдах ажилтантай бол энэ дүрмийн 175.51(a)(2)(ii):
 - (ii) аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо бий болгох, хэрэгжүүлэх болон хадгалахын оронд тухайн байгууллагад энэ дүрмийн 175.303-т нийцсэн дотоод чанар хангалтынтогтолцоо бий болгосон бол дүрмийн 175.67:
 - (iii) энэ дүрмийн 175.69(a)(1A):
 - (iv) энэ дүрмийн 175.69(a)(3)(ii):
 - (v) энэ дүрмийн 175.69(a)(5A); гэхдээ
- (2) бөглөсөн САА маягтын хамт2016 оны 7-р сарын 30-аас өмнө дараах зүйлсийг тусгасан хэрэгжүүлэх төлөвлөгөөг Даргад ирүүлнэ-
- (i) аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо хэрэгжүүлэхээр төлөвлөсөн огноо; болон
 - (ii) энэ дүрмийн 175.67-дзаасан аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог байгууллагад хэрхэн хэрэгжүүлэх талаар товч тайлбар.
- (c) Дарга шаардлага хангасан гэж үзвэл -
- (1) байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлана;болон
 - (2) аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх өдрийгтогтооно.
- (d) Ямар нэгэн эргэлзээ төрүүлэхгүйүүднээс аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх өдөр нь Даргын зөвшөөрөл олгосон өдөр байна.
- (e) Энэ дүрмийн 175.301(c)(2)-ын дагуу хэрэгжүүлэх өдрийг тогтоохдоо Дарга нь дараах зүйлсийг харгалзан үзнэ:
- (1) байгууллагын чадамж:
 - (2) байгууллагын бүтэц зохион байгууллалт:
 - (3) байгууллагын үйл ажиллагаануудтай холбоотой гардаг эрсдэлүүд:
 - (4) гэрчилгээний хугацаа сунгах огноо:
 - (5) нөөц болон ажлын цагийн хуваарийн хувьд байгууллага эсхүл Эрх бүхий байгууллага эсхүл хоёуланд нь үзүүлж болох нөлөө:

(6) хэрэгжүүлэх хугацаа нь 2018 оны 2-р сарын 1-ээс хойшгүй байна.

(f) Байгууллага нь нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ хүссэн өргөдөл гаргагч бол гэрчилгээ хүссэн өргөдлөө аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо хэрэгжүүлэх төлөвлөгөөний хамт ирүүлнэ.

(g) Энэ дүрэм нь 2018 оны 2-р сарын 1-нд хүчингүй болно.

175.303 Нисэхийн мэдээллийн үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч болон өргөдөл гаргагчдын шилжилтийн үеийн дотоод чанар хангалт

Энэ дүрмийн дагуу шаардсан журмуудыг мөрдөх, тэдгээрийн нийцлийг хангахын тулд энэ дүрмийн 175.301(b)(1)(ii)-т заасан дотоод чанар хангалтын тогтолцоог бий болгосон байна.

(a) Эдгээр журмуудад дараах зүйлсийг заасан байна –

- (1) өргөдөл гаргагчийн хүрэхээрзорьж буй чанарын түвшин;болон
- (2) дотоод дүн шинжилгээний түвшин ба давтамж; болон
- (3) дотоод дүн шинжилгээнүүдийг хийх үүрэгтэй ажилтан эсхүл ажилтнууд; болон
- (4) дотоод дүн шинжилгээнүүдээр илэрсэн **зүйлсийг** хэрхэн бүртгэдэг болон удирдах ажилтанд хэрхэн мэдээлэх;болон
- (5) **алдааны тайлан**, **осол** болон гомдол гэх мэт чанарын үзүүлэлтүүдийг дотоод чанар хангалтын журмуудад хэрхэн оруулах; болон
- (6) дотоод дүн шинжилгээнүүдэд задлан шинжилгээ болон үнэлгээ хийх талаар удирдах ажилтны хүлээх үүрэг;болон
- (7) дотоод дүн шинжилгээгээр илэрсэн аливаа дутагдлыг залруулах арга хэлбэрүүд; болон
- (8) дүн шинжилгээнд тавигдах баримт бичгийн шаардлагууд.

(b) Дотоод чанар хангалтыг хариуцсан удирдах ажилтан нь хэвлэгдсэн нисэхийн мэдээллийн нийцэл, үнэн зөв, **цаг хугацаандаа**, формат болон тараалттай холбоотой асуудлуудаар удирдах ажилтантай шууд харьцах боломжтой байна.

(c) Энэ дүрэм нь 2018 оны 2-р сарын 1-нд хүчингүй болно.